

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“Люкс занадугрупп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4-р сарын 30-ны өдрийн 10 цагт Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Реженси Резиденс байрны 314 тоот өрөөнд эхлэв.

Хурал зохион байгуулах комисс хурлыг холбогдох журамын дагуу зохион байгуулсан ба тооллогын комисс хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч нийт ирцийг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хуралд 78,965 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцсон нь Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалт, компанийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 95.28 хувийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсон тогтоолыг тооллогын комиссын дарга уншиж танилцуулан, хурал хүчин төгөлдөр эхлэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга тус компанийн Гүйцэтгэх Захирал Г.Гомбо хурлыг нээж хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлэв. Мөн тэрээр хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны талаарх болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах;
2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг батлах
3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, нэмэлт хувьцаа гаргах эсэх тухай
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
5. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Гүйцэтгэх захирал Г.Гомбо компанийн 2017 оны болон 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, цаашид явуулах үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг багцлан танилцуулав.

Миний бие тус компанийн захирлаар ажилладаг ба мэдээлэлийн технологи, компьютерийн мэргэжилтэй.

“Люкс занадугрупп” ХК мэдээллийн технологи, интернет орчинд суурилсан үйлчилгээ, түүний шийдэл, зөвлөх үйлчилгээ, сургалт, маркетинг, олон нийтийн харилцаа, зар сурталчилгаа, бренд менежмент, бренд бүтээгдэхүүний худалдаа, аялал жуулчлалын үйлчилгээ болон түүний шийдэл гэх мэт технологийн салбарт үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд дурьдсанчлан зах зээлийн сул орон зайг ашиглан найдвартай түншүүд, хөрөнгө оруулагчтай холбоо тогтоох, мэдээлэлийн технологийн бааз суурь үүсгэх алхам хийж хүний нөөцийн бодлогоо тодорхойлон мэдээлэлийн технологийн салбарт ажиллаж байсан туршлагатай, чадварлаг баг хамт олон бүрдүүлэн ажиллаа. Үүний дагуу дотоодын болон гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг компанийн мэргэжитэн, экспертүүдтэй уулзан зөвлөгөө авч санал бодлоо хуваалцах зэрэг хэд хэдэн бизнес уулзалтууд амжилттай хийсэн. Компанийн үйл ажиллагааг идэвхжүүлэн сэргээх зорилгоор хөрөнгө оруулалтын эх үүсвэр хайх, нэмэлт хөрөнгө оруулалт олох, бодитой хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, зах зээлийн судалгаа зэргийг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан идэвхтэй хийсэн. Санхүүгийн хувьд ашиг орлоготой байсангүй.

Бид нилээд хэдэн компанийн вэб хуудас шинээр хийж программ хөгжүүлэлтэнд анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж байна.

Мөн 2016 онд Facebook Messenger-т зориулсан “Smart Bot” ухаалаг хариулагч үйлчилгээг зах зээлд нэвтрүүлээд байна. “Smart Bot” ухаалаг хариулагч үйлчилгээг ашигласнаар байгууллагын зар сурталчилгаа, шинэ мэдээ мэдээлэлийг харилцагч бүрт хүргэх, харилцагчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох олон давуу талтай. Бид энэ шинэ бүтээгдэхүүнээ зорилтот зах зээлийн хэрэглэгчиддээ танилцуулсан ба нилээд хэдэн харилцагч нартай болсон ба одоогоор туршилтын журмаар ашиглуулж байна.



УХААЛАГ ХАРИУЛАГЧ

SMART BOT

Мөн 2016 онд Facebook Messenger-т зориулсан SMART BOT үйлчилгээг нэвтрүүлж байна.

Таны маркетинг харилцагч бүрт хүрнэ. Мэдээ, мэдээлэл, шинэ мэдээ, мэдээлэлийг харилцагч бүрт хүргэх, харилцагчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох олон давуу талтай.

Хүчид нэгдэж хамтран Facebook Messenger-т зориулсан SMART BOT үйлчилгээг нэвтрүүлж байна.

Харилцагчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох олон давуу талтай.

Холбоо барих

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Төрийн захирлын галт тэрэгний зогсоол, 10000

Цахилгаан: 9911-1111, 9911-1112, 9911-1113

Утас: 9003675, 9911-1114





суурилсан жижиглэнгийн худалдааны иж бүхэн үйлчилгээг хэрэглэгчдэд санал болгохыг зорьж байна.

Мэдээллийн технологи

Люкс Занаду Групп ХК нь мэдээллийн технологийн иж бүрэн үйлчилгээг хэрэглэгч харилцагчиддаа үзүүлэх бөгөөд үүнд програм хангамж, мэдээлэл холбооны тоног төхөөрөмж нийлүүлэлт, системийн интеграцчилал, байгууллагын нөөц төлөвлөлтийн системийн боловсронгуй болгох, үйлдвэрлэл, барилгын автоматжуулалт, мэдээлэл технологийн аудитын үйлчилгээг үзүүлэхээр төлөвлөж байна.

Интернетэд суурилсан үйлчилгээ, шийдэл

Интернетэд суурилсан үйлчилгээ, шийдэл

Зөвлөх үйлчилгээ

Мэдээллийн технологийн шийдлүүдийг ашиглан компанийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх боломжийг эрэлхийлж дэвшилтэт оновтой шийдлийг харилцагчдад санал болгож гүйцэтгэлийг хэрэгжүүлэх цаашлаад үйл ажиллагаанд хяналт мониторинг мэргэжлийн зөвлөгөөг үзүүлнэ.

Сургалт мэдээлэл

Мэдээллийн технологийн анхан шатны мэдээлэл олгох болон байгууллага, компанийн мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтнүүдэд мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах

Цахим хуудас хөгжүүлэлт

Загварт суурилсан цахим хуудас хөгжүүлэлт, бүтээлч цахим хуудас хөгжүүлэлт, нэмэлт модуль хөгжүүлэлт, мобайл хөгжүүлэлт, онлайн худалдааны шийдэл, хостинг сервер, цахим хуудасны засвар үйлчилгээ

Хэвлэл мэдээлэл, онлайн шийдэл

Интернетэд суурилсан мэдээллийн хэрэгслийн үйлчилгээ

Маркетинг, харилцаа холбоо

Маркетингийн стратеги төлөвлөлт, зөвлөх үйлчилгээ

Зар сурталчилгаа

Интернет, мэдээллийн технологид суурилсан зар сурталчилгааны шийдэл, хөгжүүлэлт, хэрэгжилт үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Олон нийтийн харилцаа

Төрийн, олон нийтийн, олон улсын байгууллагууд, компани бизнесийн байгууллагуудын олон нийттэй харилцах стратеги, арга хэрэгслийг боловсруулах, олон нийтийн харилцаатай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах

Брэнд менежмент

Зах зээлд шинээр нэвтрүүлэхээр төлөвлөж буй болон зах зээлд борлуулагчдаж буй бүтээгдэхүүн үйлчилгээний брендийн менежментийг гүйцэтгэх, зах зээлд брендийн үнэ цэнийг өсгөх

Аялал жуулчлалын менежмент

Аялал жуулчлалын менежмент

Тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүн, түүний маркетинг


Хүн амын орлогын түвшин нэмэгдэхтэй зэрэгцэн хэрэглэгчдийн худалдан авах чадвар сүүлийн жилүүдэд дээшилж байна. Энэ нөхцөл байдал нь тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт хэрэгцээг өсгөж байгаа бөгөөд цаашдаа эрэлт хэрэгцээ идэвхтэй өснө гэж хүлээгдэж байгаа юм. Иймд Люкс Занаду Групп ХК энэ энэхүү эрэлт хэрэгцээг хангахад өөрийн хувь нэмрийг оруулахаар төлөвлөж байгаа бөгөөд тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүний жижиглэнгийн борлуулалт, түүний маркетингийг хэрэгжүүлэн ажиллах юм.

Люкс Занапу Групп ХК нь дээр дурдсан олон төрлийн бизнесийн шугамуудад үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байгаа бөгөөд зах зээлийн судалгааны хэсэгт гол бизнесийн салбарууд болох мэдээллийн технологи болоод аялал жуулчлалын салбарын талаар дэлгэрүүлэн авч үзэх болно.

Мэдээллийн технологийн салбар

Мэдээллийн технологи, түүнтэй холбоотой салбаруудын зах зээл сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж 2017 оны эцсын сарын байдлаар салбарын нийт орлого 1074.4 тэрбум төгрөгт хүрсэн байна

Зураг 1. Салбарын нийт хөрөнгө оруулалт болон нийт орлого



Мэдээллийн технологийн салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ 2017 онд -25.73% буурч 173.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг нь үүрэн холбооны салбарт хийгдсэн бөгөөд энэхүү хөрөнгө оруулалтын үр дүнд Монгол Улс утасгүй холбооны сүлжээгээр хангагдаж дуусч байна. Үүрэн холбооны сүлжээ хамрах хүрээ нэмэгдэж байгаатай уялдан утастай, утасгүй интернэтийн хэрэглээний түвшин нэмэгдэж байгаа бөгөөд 2012 нийт интернет хэрэглэгчийн тоо 654.0 мянга байсан бол энэ тоо нь 2017 онд 2,910.7 мянган хэрэглэгч болтол өсжээ.

Компанийн хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зүгээс 2018 онд 5 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтыг босгож бизнес төлөвлөгөөнд тусгагдсан чиглэлүүдэд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна. Компани эхний жилдээ 5 тэрбум төгрөгийн борлуулалт гүйцэтгэх бөгөөд үйл ажиллагаа жигдэрч хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн байр суурь бэхжсэнээр борлуулалтын орлого жилд 30%-иар өсч 2022 он буюу 5 жилийн дараа 2.8 тэрбум төгрөгт хүрнэ гэж төсөөлж байна. Компанийн төлөвлөж буйгаар цэвэр ашгийн маржин 31% байхаар төлөвлөгдөж байна.

Хүснэгт 8. Орлогын төсөөлөл

Люкс Занаду Групп ХК орлогын төсөөлөл	2018E	2019E	2020E	2021E	2022E
Борлуулалтын орлого	1,000	1,300	1,690	2,197	2,856
Мэдээллийн технологи	100	130	169	220	286
Интернетэд суурилсан үйлчилгээ, шийдэл	150	195	254	330	428
Зөвлөх үйлчилгээ	50	65	85	110	143
Сургалт мэдээлэл	100	130	169	220	286
Цахим хуудас хөгжүүлэлт	50	65	85	110	143

[illegible]

Хурлын дарга Г.Гомбо: Бид компанийн цаашдын үйл ажиллагааг өргөжүүлэх, цар хүрээг тэлэх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, гадны хөрөнгө оруулагчид болон дэлхийд алдартай мэдээлэл технологийн салбарыг монголд нэвтрүүлэх, үр ашигтай ажиллах, компанийн нэр хүнд, эдийн засгийн чадавхийг сайжруулах зорилгоор нэр хүнд бүхий, компанийн ашиг орлогод нөлөө үзүүлэхүйц мэдээлэлийн технологийн компаниудаас сонгон худалдан авах нь зүйтэй гэж үзэж байна. Иймээс энэ асуудлыг хэлэлцэх асуудлын бусад гэх асуудлын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй байх хэмээн санал оруулж байна. Судлагдаж буй компаниуд нь Ази, Африк, Америк болон хөгжиж буй зах зээлүүдэд мэдээлэлийн болон техник технологи, зөвлөхийн, сургалт, судалгааны чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг олон улсад нэр хүндтэй компаниуд юм.

Хувьцаа эзэмшигч Г.Алтаймаа:

- Нэмэлт хувьцаа гаргах нь зөв гэж бодож байна. Оруулж ирсэн саналын тоо хэмжээ, нэрлэсэн үнээр хувьцаа гаргая.

Хувьцаа эзэмшигч Г.Оюунболд:

- Нэмэлт хувьцаа гаргаж хөрөнгө татан төвлөрүүлэх нь маш зөв санал байна. Бусад бүх асуудлыг дэмжиж байна. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс шаардах эрх хэрэгжүүлэх нь тун зөв. Эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид хувьцаагаа худалдаж ав гэж санал гаргасан тохиолдолд худалдаж авах хэрэгтэй. Гэхдээ энэ тохиолдолд компани төлбөрийн чадвартай үлдэх ёстойг мартаж болохгүй.

Хувьцаа эзэмшигч “Мезза Файнэншил групп” ХХК түүнийг төлөөлж Камоллиддин Талипов:

- Би хувьцаа эзэмшигч нартай санал нэг байна. Нэмэлт хувьцаа гаргах нь маш зөв. Санхүүгийн чадавхитай, сайн засаглалтай, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч сайн компани болгох хэрэгтэй. ТУЗ-д эрхийг нь өгөх нь маш зөв. Тэд ч бас хариуцлагаа хүлээх тул зөв шийдвэрийг гаргана гэдэгт итгэлтэй байна.

Гүйцэтгэх Захирал Г.Гомбо:

- Нэмэлт хувьцаа гаргах ажиллагааг бид сайн хийхээр ажиллаж байна. ТУЗ-ийн гишүүдтэй танилцаарай. Дүрмийн нэмэлт өөрчлөлт бол хувьцааны тоонд орох юм. Гол нь төлөвлөж байгаа хөрөнгөө амжилттай татан төвлөрүүлэх нь чухал. Та бүхнийхээ санал, дэмжлэгт баярлалаа.

Хувьцаа эзэмшигчид: Бүрэн дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигчдээс өөр санал, асуулт гараагүй тул санал хураалтыг эхлэв.

Саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсний дараа хурлын дарга Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга танилцуулав. Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна.

“Люкс занаду групп”ХК-ийн 2018 оны 4 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлын дагуу **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны талаарх тайланг батлах;
2. Компанийн 2018 оны хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөг батлах , үнэт цаасны болон бусад төсөл, тайлан төлөвлөгөөг батлах эрхийг ТУЗ-д өгөх
3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, нэмэлт хувьцаа гаргах асуудлыг бүрэн дэмжин зөвшөөрөх
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
5. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг дэмжих болон бусад асуудлыг дэмжихээр тогтлоо.

Хурлын дарга Г.Гомбо хурлыг хаав.
Хурал: 13.05 цагт өндөрлөв.

Хурлын дарга:  / Г.Гомбо /

Тэмдэглэл хөтөлсөн:  Э.Саранчимэг